



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/5

Мандалговь

“Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих
ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын барилгын
хэлтсийн дарга)

Гишүүд:

Т.Төрбат (Иргэний төлөөлөл)

Ө.Дугармаа (Дундговь аймаг дахь Зах зээл ба
бэлчээрийн удирдлагын хөгжил
төслийн зохицуулагч)

Б.Пэрэнлэймаа (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын
худалдан авах ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Энхмэнд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210070